



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/457

Ёсолбулаг

Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт,
хаваржилтын бэлтгэл хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэх хангах зарим арга хэмжээний тухай" 279 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Хөдөө аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах аймгийн нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг холбогдох агентлаг, сумын удирдлагуудтай хамтран зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган, хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг сум, багийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газар (Т.Сүхбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

3.Сум бүр хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хэсэг байгуулж, 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг боловсруулан, батлуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Хөдөө аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг сайтар хангуулж, дүнг 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

C:\Documents\ ZD A-4 doc

0201360598

**ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ӨВӨЛЖИЛТИЙН
БЭЛТГЭЛ ХАНГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Г.Чинбат (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Л.Хаш-Эрдэнэ (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн дарга)

Ц.Лувсанжамц (Онцгой байдлын газрын дарга)

Г.Лхагважаргал (Эрүүл мэндийн газрын дарга)

Р.Бүрэнбаясах (Мал эмнэлгийн газрын дарга)

Г.Болдбаатар (Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын дарга)

Н.Алтантуяа (Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн
дарга)
(Сумын Засагдарга нар)

Нарийн бичгийн дарга: Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)